



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймгийн Эрүүл мэндийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/87/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2020 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас:70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn Аудитор: С.Энхбаатар Утас: 70584207 Цахим хаяг: Enkhbaatars@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
НЭМҮТ	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан



Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.	8
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Менежментийн захидал.....	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.02.27 № 216

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Эрүүл мэндийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрүүл мэндийн газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520160



“Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.1. Оршил

Дорнод аймгийн Эрүүл мэндийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Ч.Оюунаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Эрүүл мэндийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Эрүүл мэндийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 18-наас 2020 оны 02 дугаар сарын 21-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор С.Энхбаатар хариуцаж хэрэгжүүлэв.

Дорнод аймгийн Эрүүл мэндийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 23-ний өдрийн 1/69 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас

санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорнод аймгийн Эрүүл мэндийн газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Аймгийн эрүүл мэндийн салбарын хэмжээнд удирдлагын болон нөөцийн үр ашгийг дээшлүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бодлогыг оновчтой хэрэгжүүлэн үйлчлүүлэгчдэд ээлтэй, тэгш хүртээмжтэй чанартай тусламж үйлчилгээ хүргэх замаар хүн амын эрүүл мэндийг сайжруулах”-д оршино.

Дорнод аймгийн Эрүүл мэндийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргаас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Дорнод аймгийн Эрүүл мэндийн газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Эрүүл мэндийн газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Acolous программ хангамж ашигладаг байна.

Дорнод аймгийн Эрүүл мэндийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорнод аймгийн Эрүүл мэндийн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 15 эрсдэлтэй асуудалд 15 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,597,537.2 мянган төгрөгөөс тооцон 31,950.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд тайлант үеийн гүйцэтгэлээр материаллаг байдлын түвшинг 40,263.2 мянган төгрөгөөр тооцсон.

2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дорнод аймгийн Эрүүл мэндийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 89,390.9 мянган төгрөгөөр буюу 12.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	00.0	00.0	00.0
Авлага	1,279.8	00.0	-1,279.8
Бараа материал	71,498.1	67,331.6	-4,166.5
Үндсэн хөрөнгө	1,039,100.3	1,229,031.7	189,931.4
Үндсэн хөрөнгийн элэгдэл	-38,4371.7	-479,465.9	-95,094.2
Нийт хөрөнгө	727,506.5	816,897.4	893,90.9
Өр төлбөр	1,449.9	00.0	-1,449.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	726,056.6	816,897.4	90,840.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	727,506.5	816,897.4	89,390.9

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь эм боох материал болон түлш, шатах тослох материалын өмнөх оны үлдэгдлийг зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь ЭМЯ-аас тээврийн хэрэгсэл, ХӨСҮТ-өөс вакцины хөргөгч, ОНХС-ийн хөрөнгөөр тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгө үнэ төлбөргүйгээр шилжүүлж өгсөн, өөрийн төсвийн хөрөнгөөр тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авснаас шалтгаалжээ. Тээврийн хэрэгсэл 115500.0 мянган төгрөгөөр, тоног төхөөрөмж 37293.7 мянган төгрөгөөр, тавилга, эд хогшил 8082.3 мянган төгрөгөөр, бусад үндсэн хөрөнгө 29055.4 мянган төгрөгөөр, нийт дүнгээр 189931.4 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 816,390.9 мянган төгрөг болж 89,390.9 мянган төгрөгөөр өссөн нь үйл ажиллагааны үр дүн нэмэгдсэнээс шалтгаалжээ. Энэ нь хөрөнгө оруулалтаар хөрөнгө хүлээн авч нэмэгдсэн байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 8 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй. Тус байгууллагын хувьд орлогын төлөвлөгөө байхгүй байна.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 1,463,636.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,463,636.9 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,460,867.9 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөгджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,460,867.9 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь тайлант хугацаанд төсвийн хуваарийн дагуу зардлыг зарцуулсантай холбоотой байна.

Нэмэлт төсөв: ЭМЯ-аас 58,137.4 мянган төгрөг, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй хөрөнгөнөөс 300,947.1 мянган төгрөг, ХӨСҮТ-өөс 18,431.8 мянган төгрөг, НЭМҮТ-өөс 12,734.0, мянган төгрөг, цахим тендерийн орлогоос 594.0 мянган төгрөг, бусад нэмэлт орлогоос 7,816.4 мянган төгрөг, нийт 398,660.7 мянган төгрөгийн нэмэлт төсвийг бүрдүүлжээ. Үүнээс тээвэр шатахууны зардалд 8,524.2 мянган төгрөг, багаж, техник хэрэгслийн зардалд 54,106.0 мянган төгрөг, томилолтын зардалд 8,464.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 327,566.5 мянган төгрөг, нийт 398,660.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 15 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 16 эрсдэл тодорхойлж, нийт 16 горим сорил хэрэгжүүлжээ.

Аудитаар нийт 32,821.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 3,849.6 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 20,676.9 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 8,294.6 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгч ажиллалаа. Үүнд:

1. Цалингийн зардлаас 1,209.6 мянган төгрөгийн нэмэгдлийг тушаал шийдвэргүйгээр тооцож олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Тайлант оны эцэст 2,640.0 мянган төгрөгийн шатахууныг нөөцлөн он дамжуулан зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5-д “Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй.” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

3. Нийт бараа материалын худалдан авалтын 20,353.6 мянган төгрөгийн Е-баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д “анхан шатны баримт” гэж ..., төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13 дугаар зүйлийн 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.”, Сангийн Сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5, Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч Е баримтыг хавсаргах” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
4. Нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас 323.3 мянган төгрөгийг цалинд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар илэрсэн 8,294.6 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц чухал асуудал байхгүй.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Эрүүл мэндийн газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 142 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.12. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 албан шаардлага өгснийг хэрэгжүүлсэн байна.

2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрүүл мэндийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорнод аймгийн Эрүүл мэндийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. *МУЕА-аас өгсөн чиглэлийн дагуу суудлын автомашины ашиглалтын талаар*
 - 1.1. *Илрүүлэлт*: Байгууллагын дарга нь ЗГ-ын 2015 оны 184-р тушаалын хавсралтаар батлагдсан автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалтад хамаарахгүй байхад хот дотор тодорхой ажлын гүйцэтгэлгүйгээр 3,952.0 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан байна.
 - 1.2. *Эрсдэл*: Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах.
 - 1.3. *Өгсөн зөвлөмж*: Холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах.
 - 1.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар*: Өгсөн зөвлөмжийн дагуу ажиллах болно
2. *Зардлын данстай холбоотой асуудал*:
 - 2.1. *Илрүүлэлт*: Байр ашиглалттай холбоотой 4,342.6 мянган төгрөгийн тогтмол зардлыг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн байна.
 - 2.2. *Эрсдэл*: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.
 - 2.3. *Өгсөн зөвлөмж*: Сангийн Сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ыг мөрдөж ажиллах.
 - 2.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар*: Өгсөн зөвлөмжийг мөрдөж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.1 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		/төгрөгөөр/	
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	72,777,912.87	67,331,612.70
33	АВЛАГА	1,279,845.37	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	20,000.00	00.00
335	Бусад авлага	1,259,845.37	00.00
3351	Байгууллагаас авах авлага	1,259,845.37	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	71,498,067.50	67,331,612.70
351	Түүхий эд материал	27,451,459.50	12,808,607.50
35110	Тусгай зориулалттай материал	4,584,000.00	7,784,000.00
35130	Эм боох материал	22,867,459.50	5,024,607.50
354	Хангамжийн материал	44,046,608.00	54,523,005.20
35410	Бичиг хэргийн материал	1,337,738.00	3,424,690.00
35420	Аж ахуйн материал	10,760,421.00	11,729,508.50
35430	Сэлбэг хэрэгсэл	8,236,204.54	8,552,804.54
35440	Түлш, шатах тослох материал	5,490,000.00	2,640,000.00
35450	Барилгын засварын материал	744,850.00	111,000.00
35470	Бусад хангамжийн материал	17,477,394.46	28,065,002.16
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	654,728,593.24	749,565,820.50
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	654,728,593.24	749,565,820.50
392	Биет хөрөнгө	636,428,093.18	731,265,320.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	115,875,543.50	115,875,543.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	891,891.90	-2,619,488.22
39203	Авто-тээврийн хэрэгсэл	206,351,285.00	321,851,285.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-133,543,605.33	-143,451,604.17
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	455,489,243.85	492,782,903.85
39206	Хуримтлагдсан элэгдэл	-191,704,320.20	-240,977,738.01
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	44,960,887.00	53,043,187.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-33,827,494.47	-38,479,102.26
39214	Бусад үндсэн хөрөнгө	196,603,362.00	225,658,762.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-24,668,700.07	-52,418,428.25
393	Биет бус хөрөнгө	18,300,500.06	18,300,500.06
39301	Програм хангамж	1,520,000.00	1,520,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,519,499.94	-1,519,499.94
39303	Бусад биет бус хөрөнгө	18,300,000.00	18,300,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	727,506,506.11	816,897,433.20
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,449,933.37	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,449,933.37	00.00
413	Өглөг	1,449,933.37	00.00
4136	Бусад өглөг	1,449,933.37	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,449,933.37	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	726,056,572.74	816,897,433.20
51	Засгийн газрын хувь оролцоо	726,056,572.74	816,897,433.20
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	560,705,978.44	560,705,978.44
51101	Өмч: - төрийн	560,705,978.44	560,705,978.44
512	Хуримтлагдсан үр дүн	480,432,711.77	571,273,572.23
51210	Өмнөх үеийн үр дүн	480,432,711.77	480,432,711.77
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	90,840,860.46
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-315,082,117.47	-315,082,117.47

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	727,506,506.11	816,897,433.20
---	---	-----------------------	-----------------------

4.2 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,708,556,172.00	2,104,001,725.56
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	900,000.00	241,704,090.56
120	Нийтлэг татварын бус орлого	900,000.00	241,704,090.56
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	241,704,090.56
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	241,704,090.56
120009	Бусад орлого	900,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,707,656,172.00	1,862,297,635.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,327,122,200.00	1,463,636,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,327,122,200.00	1,463,636,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	380,533,972.00	398,660,735.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	46,865,710.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	300,769,473.00	300,947,091.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	75,419,499.00	43,031,570.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,345,000.00	7,816,364.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,597,537,190.35	2,013,160,865.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,597,537,190.35	2,013,160,865.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	818,434,044.95	1,170,569,072.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	416,908,039.86	457,736,295.14
210101	Үндсэн цалин	416,899,728.86	457,736,295.14
210102	Нэмэгдэл	8,311.00	00.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,584,243.32	57,115,997.84
210201	Тэтгэврийн даатгал	33,252,481.56	39,378,613.14
210202	Тэтгэмжийн даатгал	4,156,560.07	4,511,989.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,325,248.06	3,609,589.22
210204	Ажилгүйдлийн даатгал	804,541.51	874,163.09
210205	Эрүүл мэндийн даатгал	8,045,412.12	8,741,642.88
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,872,946.00	9,496,400.00
210301	Гэрэл, цахилгаан	3,772,000.00	4,233,088.00
210302	Түлш, халаалт	10,047,387.00	3,737,794.00
210303	Цэвэр, бохир ус	2,053,559.00	1,525,518.00
210304	Байрны түрээс	00.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	38,948,452.97	42,754,910.60
210401	Бичиг хэрэг	9,097,015.97	5,626,713.40
210402	Тээвэр, шатахуун	28,125,537.00	35,328,030.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,139,700.00	1,335,500.25

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	365,700.00	314,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	220,500.00	150,066.95
210408	Бараа материал акталсны зардал	00.00	00.00
2105	Нормативт зардал	42,135,423.00	161,770,742.56
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	42,100,423.00	161,580,742.56
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	35,000.00	190,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,774,660.00	14,369,156.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	28,919,960.00	00.00
210602	Тавилга	00.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,266,900.00	167,350.00
210604	Урсгал засвар	1,587,800.00	14,201,806.00
2107	Томилолт, зочны зардал	16,676,095.00	22,940,000.00
210701	Гадаад албан томилолт	00.00	5,980,000.00
210702	Дотоод албан томилолт	16,676,095.00	16,960,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,253,309.53	10,354,971.53
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,959,510.00	1,282,442.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	212,900.00	548,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	75,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,005,899.53	8,190,629.53
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	194,280,875.27	394,030,598.61
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	170,131,047.00	271,921,397.87
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,540,955.00	27,015,068.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,608,873.27	95,094,132.74
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	779,103,145.40	842,591,792.82
2132	Бусад урсгал шилжүүлэг	750,798,963.00	839,431,922.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	269,878,800.00	541,327,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	480,920,163.00	298,104,422.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,304,182.40	3,159,870.82
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,304,182.40	3,159,870.82
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>111,018,981.65</u>	<u>90,840,860.46</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	22,000,000.00	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	22,000,000.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>89,018,981.65</u>	<u>90,840,860.46</u>

4.3 АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,707,656,172.00</u>	<u>1,862,297,635.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,707,656,172.00	1,862,297,635.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,327,122,200.00	1,463,636,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,327,122,200.00	1,463,636,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	380,533,972.00	398,660,735.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	46,865,710.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	300,769,473.00	300,947,091.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	75,419,499.00	43,031,570.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,345,000.00	7,816,364.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,579,690,382.00</u>	<u>1,862,297,635.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,579,690,382.00	1,862,297,635.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	800,587,236.60	1,019,382,547.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	418,476,964.60	457,839,342.83
210101	Үндсэн цалин	336,037,100.00	304,053,000.00
210102	Нэмэгдэл	9,384,300.00	88,606,742.83
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,776,064.60	31,336,600.00
210104	Урамшуулал	27,279,500.00	33,843,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,619,300.00	56,730,000.00
210201	Тэтгэврийн даатгал	33,746,200.00	38,576,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,218,300.00	4,538,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,374,600.00	3,630,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	843,700.00	907,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,436,500.00	9,076,800.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,872,946.00	9,496,400.00
210301	Гэрэл, цахилгаан	3,772,000.00	4,233,088.00
210302	Түлш, халаалт	10,047,387.00	3,737,794.00
210303	Цэвэр, бохир ус	2,053,559.00	1,525,518.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,118,375.00	32,712,527.07
210401	Бичиг хэрэг	4,110,150.00	3,775,200.00
210402	Тээвэр, шатахуун	24,889,025.00	24,634,030.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,139,700.00	1,278,097.07
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	365,700.00	411,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,613,800.00	2,613,800.00
2105	Нормативт зардал	28,333,700.00	9,573,370.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	27,867,950.00	9,095,670.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	465,750.00	477,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,024,410.00	76,247,709.40
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,669,960.00	54,106,010.00
210602	Тавилга	00.00	5,000,000.00

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,348,600.00	3,431,203.00
210604	Урсгал засвар	2,005,850.00	13,710,496.40
2107	Томилолт, зочны зардал	16,585,600.00	22,740,000.00
210701	Гадаад албан томилолт	00.00	5,980,000.00
210702	Дотоод албан томилолт	16,585,600.00	16,760,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,048,410.00	11,768,971.53
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,959,510.00	1,282,442.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	212,900.00	548,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	75,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,801,000.00	9,604,629.53
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	201,507,531.00	342,274,226.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	199,424,631.00	311,191,326.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,082,900.00	31,082,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	779,103,145.40	842,915,087.77
2132	Бусад урсгал шилжүүлэг	750,798,963.00	839,755,216.95
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	269,878,800.00	541,327,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	480,920,163.00	298,104,422.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	323,294.95
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,304,182.40	3,159,870.82
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,304,182.40	3,159,870.82
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>127,965,790.00</u>	<u>00.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	127,965,790.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	127,965,790.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	127,965,790.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ, ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	/ төгрөгөөр /
						Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	542,405,978.44	00.00	391,413,730.12	00.00	933,819,708.56
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	542,405,978.44	00.00	391,413,730.12	00.00	933,819,708.56
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	18,300,000.00	00.00	89,018,981.65	00.00	107,318,981.65
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	560,705,978.44	-315,082,117.47	480,432,711.77	00.00	726,056,572.74
D01	2019 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	560,705,978.44	-315,082,117.47	480,432,711.77	00.00	726,056,572.74
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	560,705,978.44	-315,082,117.47	480,432,711.77	00.00	726,056,572.74
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	90,840,860.46	00.00	90,840,860.46
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	560,705,978.44	-315,082,117.47	571,273,572.23	00.00	816,897,433.20

4.5 АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,463,637,000.00	1,460,867,871.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,463,637,000.00	1,460,867,871.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	621,227,300.00	621,112,654.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	457,839,700.00	457,839,342.83
210101	Үндсэн цалин	304,053,000.00	304,053,000.00
210102	Нэмэгдэл	88,607,100.00	88,606,742.83
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,336,600.00	31,336,600.00
210104	Урамшуулал	33,843,000.00	33,843,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,730,000.00	56,730,000.00
210201	Тэтгэврийн даатгал	38,576,400.00	38,576,400.00

210202	Тэтгэмжийн даатгал	4,538,400.00	4,538,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,630,700.00	3,630,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	907,700.00	907,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,076,800.00	9,076,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,496,400.00	9,496,400.00
210301	Гэрэл, цахилгаан	3,772,000.00	4,233,088.00
210302	Түлш, халаалт	4,030,100.00	3,737,794.00
210303	Цэвэр, бохир ус	1,694,300.00	1,525,518.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,050,000.00	24,049,900.00
210401	Бичиг хэрэг	3,775,200.00	3,556,611.60
210402	Тээвэр, шатахуун	16,109,800.00	16,109,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,139,700.00	1,358,288.40
210404	Ном, хэвлэл	00.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	411,400.00	411,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,613,900.00	2,613,800.00
2105	Нормативт зардал	9,687,500.00	9,573,370.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,209,800.00	9,095,670.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	477,700.00	477,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,141,700.00	22,141,699.40
210602	Тавилга	5,000,000.00	5,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,049,700.00	3,431,203.00
210604	Урсгал засвар	14,092,000.00	13,710,496.40
2107	Томилолт, зочны зардал	14,276,000.00	14,276,000.00
210702	Дотоод албан томилолт	14,276,000.00	14,276,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,965,400.00	11,965,342.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,282,500.00	1,282,442.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	548,900.00	548,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,801,000.00	9,801,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15040600.00	15040600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,957,700.00	12,957,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,082,900.00	2,082,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	842409700.00	839755216.95
2132	Бусад урсгал шилжүүлэг	842,409,700.00	839,755,216.95
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	543,454,700.00	541,327,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	298,135,000.00	298,104,422.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	820,000.00	323,294.95
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,463,636,900.00	1,463,636,900.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,463,636,900.00	1,463,636,900.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,463,636,900.00	1,463,636,900.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	23.00	23.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	19.00	19.00
620003	Үйлчлэх ажилтан	03.00	03.00
620004	Гэрээт ажилтан	00.00	00.00

